



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

“Монголын бүх ард түмний зуны XVI
наадам”-д оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймагт зохион байгуулагдах “Монголын бүх ард түмний зуны XVI наадам”-ын шигшээ тэмцээнд дүүргээс шалгарсан баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2.Уг наадамд оролцоход шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3.Наадамд оролцоход шаардагдах 4.998.000 (Дөрвөн сая есөн зуун ерэн найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 11-ны өдрийн
А/190 дугаар захирамжийн хавсралт

БҮХ АРД ТҮМНИЙ ЗУНЫ XVI НААДАМД
ОРОЛЦОХ ТАМИРЧДЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоолны зардал Чөлөөт бөх-5 Самбо-4 Жудо-4 Буудлага-3 Даам-1 (17 тамирчин өдрийн 2 хоолтой)	6 өдөр	204	24.500	4.998.000
Нийт зардал					4.998.000